

## ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2011.03.15

Иргэдэд ажил үйлчилгээгээ нээлттэй ил тод хүргэх үүднээс байгууллагын цахим хаяг, вэб хуудасыг Төрийн байгууллагуудын нэгдсэн цахим сүлжээнд <http://www.Khentii.gov.mn> хаягаар байршуулж, иргэдээс санал хүсэлт, гомдол мэдээллийг хүлээн авах, иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулж, төрөл бүрийн мэдээллийг тавьж байршуулан тогтмол баяжилт хийж байна.

Байгууллагын ил тод, шударга, иргэдэд нээлттэй байдлыг хангах зорилгоор НҮБ-ын ХХГ, АТГ-тай хамтран хэрэгжүүлж буй “Монгол улсад шударга ёс ил тод байдлыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь” төслийн багтай хамтран ажиллаж Авилгын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Засгийн газрын 2009 оны 143-р тогтоолоор батлагдсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-тэй уялдуулан боловсруулсан байна.

Засгийн газрын 2009 оны 143-р тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн албаны хүнд суртал, иргэдийг чирэгдүүлдэг, хариуцлагагүй, ёс зүйгүй байдлыг арилгах зорилгоор аймгийн Засаг даргын санал болгосноор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор “Төрийн байгууллагын шударга ёс, ил тод байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө” боловсруулах ажлын хэсгийг 12 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, байгууллага иргэдийн санал авах ажлыг нээлттэй зохион байгуулан, мөн Авлигатай тэмцэх газрын санал зөвлөгөөг тусгаж “Төрийн байгууллагын шударга ёс, ил тод байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө”-г аймгуудаас анх удаа батлан гаргаж мөрдөн ажиллаж байна. Уг төлөвлөгөөнд авлигаас урьдчилан сэргийлэх, хүнд суртал, чирэгдлийг таслан зогсоох, төрийн захиргааны байгууллагын нээлттэй ил тод байдлыг хангаж ажиллах чиглэлээр нийт 4 тулгуур, 6 зорилт бүхий 20 заалт тусгаж, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн 35% буюу 8.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулсан байна.

Уг төлөвлөгөөний дагуу төрийн байгууллагуудад мөрдөж байгаа дүрэм журам, ажлын байрны тодорхойлолт зэрэг баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, байгууллагууд нээлттэй утас ажиллуулж иргэдийн санал хүсэлтийг хүлээн авдаг боллоо. Ёс зүйтэй манлайллыг аймгийн төрийн байгууллагын удирдлагууд өөрсдөөсөө эхэлж, шударга ёс хуулийг дээдлэн ажиллах, гаргаж буй шийдвэр, явуулж байгаа үйл ажиллагаагаа олон

түмэнд ил тод нээлттэй байлгах, нийтийн эрх ашгийн хүрээнд гаргаж буй шийдвэрийг боловсруулахдаа иргэд, олон нийтийг оролцуулж саналыг нь авч байх уриалга гарган ажиллаж байна. Ил тод байдлыг хангах зорилгоор аймгийн хэмжээнд 1475 иргэнээс санал асуулга авч, шударга ёс ил тод байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан иргэдийн төлөөлөл, ИНБ-ын сүлжээтэй хамтран 2 удаа хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.

Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны талаарх мэдээллийг Сангийн яамны худалдан авах ажиллагааны [www.e-procurement.mn](http://www.e-procurement.mn) хаягаар зар хүргэж ажилласан хэдий ч тухайн үед байгууллагын цахим хуудас хийгдээгүй байсан учраас орон нутгийн цахим хуудсаар мэдээлээгүй байна.

Аймгийн хэмжээнд бүх төрийн байгууллагууд “Шударга, ил тод төрийн байгууллага” нэртэй ижил загвар, хэмжээтэй самбартай болж, түүнд тухайн байгууллагын удирдлагаас гаргасан шийдвэр, зарцуулсан төсөв хөрөнгө, зарлагдсан ажлын байр, тендерийн талаарх мэдээлэл г.м чухал шаардлагатай мэдээллүүдийг тогтмол тавьж хэвшүүлсэн нь төрийн байшууллагууд иргэдэд ил тод, нээлттэй ажиллах чиглэлд зохих ахиц, дэвшил гарсан гэж дүгнэж байна.

Ил тод байдлын үнэлгээний нийт дундаж оноо 95,3 хувь буюу 4,76 байна.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ